



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Цөмийн шинжилгээний нэгдсэн институтэд
төлөх Монгол улсын гишүүний татварын талаар

Цөмийн энергийн комиссын дүрмийн 1.2, 3.5, 4.1.2, 9.1, Засгийн газрын “Олон улсын байгууллага, гэрээ, конвенцын итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай” 2007 оны 60 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 364 дүгээр тогтоолд заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Олон улсын Засгийн газар хоорондын байгууллага Цөмийн шинжилгээний нэгдсэн институт (ЦШНИ)-д төлөх Монгол Улсын гишүүний татварын талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхийг Цөмийн энергийн комиссын дарга (Л.Энх-Амгалан)-д даалгасугай.

2. ЦШНИ-д төлөх Монгол Улсын гишүүний татварын зардлыг жил бүрийн төсөвт суулгаж, хугацаанд нь төлж байхыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Х.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд даалгасугай.

ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН

0100074